



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 10

Сүхбаатар сум

2024 оны 4 дүгээр улиралд хийсэн дотоод  
аудитын дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан дараах төсвийн төвлөрүүлэн захирагч /Баруунбүрэн, Ерөө, Сүхбаатар, Мандал, Хушаат, Жавхлантай/-ийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар илэрсэн зөрчлийн дүн, аудитын дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн сахилга бат, үр ашиг, үр нөлөө, ил тод байдлыг ханган ажиллах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Төсвийн төвлөрүүлэн захирагч нарт даалгасугай.

Гурав. Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

Хорооны дарга:



Н.Лхагвадорж

(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

Т.Мөнхзул

(Ахлах дотоод аудитор)

Гишүүд:

Т.Одсүрэн

(Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)

Ө.Сувдаа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

4324009010

Х.Мөнхжаргал  
(Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Янжинлхам  
(Хууль зүйн хэлтсийн дарга)

А.Дашбат  
(Иргэний төлөөлөл)

А.Гэрэлмаа  
(Иргэний төлөөлөл)

Дотоод аудитын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны  
өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ДОТООД АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ЖАГСААЛТ

д/д	Байгууллагын нэр	Илэрсэн зөрчлийн дүн	Аудитын дүгнэлт
1	Баруунбүрэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	164,923.4	"Сайжруулах шаардлагатай"
2	Мандал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1,925,870.9	"Сайжруулах шаардлагатай"
3	Хушаат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	247,315.1	"Сайжруулах шаардлагатай"
4	Жавхлант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	137,615.8	"Сайжруулах шаардлагатай"
5	Ерөө сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	931,715.9	"Сайжруулах шаардлагатай"
6	Сүхбаатар сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	3,407,441.1	"Сайжруулах шаардлагатай"